



НИЙСЛЭЛИЙН АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2019 оны 08 сарын 06 өдөр

Дугаар А/65

Улаанбаатар хот

┌ Зочид буудал, дэн буудал, амралтын
газрын үйл ажиллагаа эрхлэх
зөвшөөрөл олгох, хүчингүй болгох
тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 33 дугаар зүйлийн 33.5 дахь заалт, Аялал жуулчлалын тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2011 оны 120 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам”-ын 5.1, Газрын дүрмийн 2.5.3-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Зочид буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 4588:2008” стандартын шаардлагыг хангасан, тушаалын нэгдүгээр хавсралтад дурдсан аж ахуйн нэгжүүдэд зочид буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

2. “Улаанбаатар хотын нутаг дэвсгэрт аялал жуулчлалын байр сууцны үйл ажиллагаа эрхлэх журам” болон “Дэн буудалд тавигдах ерөнхий шаардлага MNS 5738:2007” стандартын шаардлагыг хангасан, тушаалын хоёрдугаар хавсралтад дурдсан, аж ахуйн нэгжүүдэд дэн буудлын үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрлийг нэг жилийн хугацаатай олгосугай.

3. Энэ тушаал гарсантай холбогдуулан Хандү ХХК-ийн “Хандү” зочид буудлын 18/341, Мон-Тул ХХК-ийн “Жи Ди Эл” зочид буудлын 18/316, Бодь Мөр Интернэшнл ХХК-ийн “Ниппон” зочид буудлын 18/269, Авдар Өргөө ХХК-ийн “Жэй” зочид буудлын 18/267, Дипломат Байгууллагын Үйлчилгээг Эрхэлсэн Газар-ийн “Дипломат” зочид буудлын 18/225, Нэгдэлч ХХК-ийн “Нэгдэлчин” зочид буудлын 18/219, Тунамал алтан зоос ХХК-ийн “Стар” зочид буудлын 18/174, Сэрх Уул ХХК-ийн “Алтан Цайз” дэн буудлын 18/246, Хэрлэн Буян ХХК-ийн “Икс Найт” дэн буудлын 18/61, ЦЦР ХХК-ийн “Аз” дэн буудлын 18/202, ЦПО ХХК-ийн “Од” дэн буудлын 18/284, Хэрлэн буян ХХК-ийн “Лойт хаус” дэн буудлын 18/108, Шандговь аттракшн ХХК-ийн “Говь аттракшн”


дэн буудлын 18/215, Аглаг-Эрдэнэ ХХК-ийн "Аглаг-Эрдэнэ" дэн буудлын 18/308 гэрчилгээг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

4. Зөвшөөрөл авсан байгууллага болон иргэдтэй гэрээ байгуулж үр дүнг тооцон ажиллахыг Захиргааны хэлтэс /Д.Ганболд/-т үүрэг болгосугай.

5. Энэхүү тушаалыг Нийслэлийн Цагдаагийн газар болон дүүргүүдийн Засаг даргын Тамгын газарт хүргүүлэхийг үйлчилгээний чанар, стандарт хариуцсан мэргэжилтэн /Ч.Энх-Отгон /-д үүрэг болгосугай.

6. Гэрчилгээний үнэ болох 5000 /таван мянга/ төгрөгийг тухайн байгууллагаас хураан, Төрийн сан банкны 100200051053 тоот дансанд төвлөрүүлэн, зөвшөөрлийн гэрчилгээний бичилт, олголтод байнгын хяналт тавьж ажиллахыг Ахлах нягтлан бодогч /Б.Батцоож/-д даалгасугай.

ДАРГА



Д.БАТСҮХ

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 08
сарын 06 өдрийн А/Б5 дугаар
тушаалын нэгдүгээр хэвсрэлт

5284025 СБТ 8936 1118263502

ЗОЧИД БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.08.06

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|---|-------------------------------|-------------|--|
| 1 | Хандү ХХК | 6188575 | Хандү | БГД-ийн, 6-р хороо, Чингүнжавын гудамж 8 |
| 2 | Мон-Тул ХХК | 2112752 | Жи Ди Эл | БГД-ийн, 20-р хороо, Үйлдвэрийн баруун бүс-/16100/ |
| 3 | Баруун-Оргил ХХК | 5432685 | Бадрал | БГД-ийн, 20-р хороо, Толгойт 2-р цахилгаан станцын баруун талд |
| 4 | Бодь Мөр Интернэшнл ХХК | 2622912 | Ниппон | БГД-ийн, 4-р хороо, Нарны зам гудамж 461/1 |
| 5 | Авдар Өргөө ХХК | 5234476 | Жэй | СБД-ийн, 1-р хороо, Автозамчдын 34 |
| 6 | Дипломат Байгууллагын үйлчилгээг эрхлэх газар | 5112303 | Дипломат | ЧД-ийн, 4-р хороо, Лааганы гудамж |
| 7 | Нэгдэлч ХХК | 2095688 | Нэгдэлчин | БЗД-ийн, 6-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 33/1 |
| 8 | Тунамал алтан зоос ХХК | 5272459 | Стар | БГД-ийн, 12-р хороо, Хасбаатарын гудамж 6-1 |
| 9 | Авто ойл ХХК | 2675366 | Люкс ойл | СХД-ийн, 18-р хороо, Энхтайваны өргөн чөлөө 163 тоот |
| 10 | Нандинхүү | 2878925 | Нобел | БЗД-ийн, 5-р хороо, Энхтайваны өргөн чөлөө |

Нийслэлийн Аялал жуулчлалын
газрын даргын 2019 оны 08
сарын 06 өдрийн А/65 дугаар
тушаалын хоёрдугаар хавсралт

ДЭН БУУДЛЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ЭРХЛЭХ
ЗӨВШӨӨРӨЛ ОЛГОХ АЖ АХУЙН НЭГЖИЙН
ЖАГСААЛТ

2019.08.06

Улаанбаатар хот

| Д/д | Иргэн, аж ахуйн нэгжийн нэр | Эзэмшигчийн регистрийн дугаар | Оноосон нэр | Байршил |
|-----|-----------------------------|-------------------------------|---------------|---|
| 1 | Сэрх-Уул ХХК | 2657112 | Алтан цайз | БЗД-ийн, 22-р хороо, Өлгийн 10/154 |
| 2 | Хэрлэн Буян ХХК | 2547163 | Икс найт | БЗД-ийн, 3-р хороо, Сансарын үйлчилгээний төв. |
| 3 | Шинэ Жигүүр ХХК | 5339685 | Кровн | СБД-ийн, 9-р хороо, 7-р хороолол Старт центрийн байранд |
| 4 | ЦЦР ХХК | 6297196 | Аз | СХД-ийн, 15-р хороо, Өнөр хороолол 68/а |
| 5 | ЦПО ХХК | 2650452 | Од | БЗД-ийн, 7-р хороо, Их тойруу 36 тоот |
| 6 | Хэрлэн буян ХХК | 2547163 | Лойт хаус | БГД-ийн, 11-р хороо, Хасбаатарын гудамж |
| 7 | Шандговь аттракшн ХХК | 5884896 | Говь аттракшн | СБД-ийн, 5-р хороо, Их өргөө 20-р байр 11 тоот |
| 8 | Аглаг-Эрдэнэ ХХК | 5175429 | Аглаг-Эрдэнэ | ЧД-ийн, 11-р хороо, Нуурын 19-404 тоот |

-ооОоо-